



ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР

**БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ БУУЛГАХ АЖЛЫН ЗӨВШӨӨРЛИЙН  
ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

Хүсэлт гаргагч: ...../Итгэмжлэгч/.....  
Холбоо барих утасны дугаар : .....  
Төлөвлөж буй барилга байгууламжийн нэр : .....  
Төлөвлөж буй барилга байгууламжийн байршил: .....

**Үндэслэл:**

Барилгын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дугаар заалт, 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 3.3 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/961 дүгээр захирамж.

| №  | Үндэслэл, хуулийн заалт                                                                                                                                                                   | Баримт бичгийн жагсаалт, тайлбар                                                                                                       | Бүрдэл |
|----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------|
| 1  | 2                                                                                                                                                                                         | 3                                                                                                                                      | 4      |
| 1. | Барилгын тухай хууль 20.3.3д, 37.1 Барилгын ажлын захиалагч нь барилга байгууламжийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу бүрдүүлнэ. | Захиалагчийн өргөдөл, албан бичиг.<br>Иргэний үнэмлэх, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар<br>Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ          |        |
| 2. | Барилгын тухай хууль 20.3.3.а Барилга байгууламжийн байршил, газрын бүртгэлийн мэдээлэл, загвар зураг, техникийн нөхцөлийг баталгаажуулсан шийдвэр.                                       | Газар эзэмших эрхийн гэрчилгээ, кадастрын зураг.                                                                                       |        |
| 3. | Барилга байгууламжийг буулгах шийдвэр                                                                                                                                                     | Барилгыг буулгах шийдвэр<br><i>/Жич: Зөвхөн төрийн өмчийн барилгад шаардана./</i>                                                      |        |
| 4. | Барилгын тухай хууль 20.3.3.г гэнэтийн ослын болон хариуцлагын даатгалд даатгуулсан баримт;                                                                                               | Гэнэтийн ослын болон хариуцлагын даатгалд даатгуулсан баримт;<br><i>Жич: Хугацаа хүчин төгөлдөр байх.</i>                              |        |
| 5. | Барилгын тухай хууль 20.3.3.д барилгын ажлын захиалагч, гүйцэтгэгчийн талаарх мэдээлэл;                                                                                                   | Барилгын буулгалтын ажлын ерөнхий гүйцэтгэгч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ,<br>Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар. |        |

| №   | Үндэслэл, хуулийн заалт                                                                                                                                                                                                                                                                                                                                          | Баримт бичгийн жагсаалт, тайлбар                                                                                                                                                                                                  | Бүрдэл |
|-----|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------|
| 1   | 2                                                                                                                                                                                                                                                                                                                                                                | 3                                                                                                                                                                                                                                 | 4      |
| 6.  | Барилгын тухай хууль 20.3.3.е<br>төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, санхүүгийн чадавхыг нотлох баримт.                                                                                                                                                                                                                                                        | Төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, санхүүгийн чадавхыг нотлох баримт.                                                                                                                                                          |        |
| 7.  | Барилгын тухай хууль 16.3.<br>“Барилга байгууламжийг буулгах үйл ажиллагааны дүрэм” БД20-101-12<br>Барилга байгууламжийн угсралт, буулгалтын ажлыг гүйцэтгэхдээ барилгын ажлын талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөл боловсруулна.                                                                                                         | Барилга байгууламжийн угсралт, буулгалтын ажлыг гүйцэтгэхдээ барилгын ажлын талбайн зохион байгуулалтын зураг төслийг барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр баталгаажуулж ирүүлэх.                                                 |        |
| 8.  | Барилгын тухай хууль 30.1<br>Барилгын ажлыг гүйцэтгэх бодит хугацааг тусгасан төлөвлөгөөг хавсаргана.<br>Барилгын ажлын зөвшөөрлийг барилгын ажил хэрэгжүүлэх төлөвлөгөөнд заасан хугацаагаар олгоно. Хугацааг барилгын ажил эхлүүлэхээр заасан өдрөөс эхлэн тооцно.                                                                                             | Барилгын ажлын үе шатанд тавих хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх календарчилсан график төлөвлөгөөг баталгаажуулж ирүүлэх.<br><br><i>Жич: Барилгын ажлын зөвшөөрлийг календарчилсан график төлөвлөгөөнд заасан хугацаагаар олгоно.</i>   |        |
| 9.  | “Барилга байгууламжийг буулгах үйл ажиллагааны дүрэм” БД20-101-12<br>Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 48 дугаар тушаал<br>Барилгын хог хаягдал тээвэрлэх зөвшөөрөлтэй этгээд /тээвэрлэгч/ холбогдох хууль тогтоомжид нийцсэн тээвэрлэлтийн гэрээг барилгын хог хаягдлыг үүсгэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй байгуулж тээвэрлэлтийг гүйцэтгэнэ. | Захиалагч нь барилгын хог хаягдал тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээдтэй /тээвэрлэгч/ байгуулсан холбогдох хууль тогтоомжид нийцсэн хог хаягдал тээвэрлэлтийн гэрээг ирүүлэх.<br><br><i>Жич: Хугацаа хүчин төгөлдөр байх.</i> |        |
| 10. | Барилгын гэрэл зураг хавсаргах                                                                                                                                                                                                                                                                                                                                   | Буулгах барилгын гэрэл зураг                                                                                                                                                                                                      |        |

### Зөвлөмж:

- Зөвшөөрөл хүссэн иргэн, хуулийн этгээд нь Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ гарсны дараа **Тэмдэгтийн хураамж 20.000₮-ийг Төрийн сан 100200051054** дугаар дансанд тушаана уу. **Гүйлгээний утга: Иргэн бол заавал регистрийн дугаар, цахим хаяг, аж ахуй нэгж бол байгууллагын регистрийн дугаар, цахим хаяг бичих.**
- Барилга байгууламжийн угсралт, буулгалтын ажлыг гүйцэтгэхдээ “Барилга үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм. II хэсэг. Техникийн аюулгүй ажиллагааны дүрэм БНБД 12-04-06, “Барилга байгууламжийг буулгах үйл ажиллагааны дүрэм” БД20-101-12-ийг мөрдлөг болгон барилгын ажлын талбайн орчны хөдөлмөр хамгааллын дэглэмийг сахиулж, гуравдагч этгээдийг барилгын ажлаас шалтгаалсан болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй.

Хүсэлт хүлээн авсан ажилтан ..... ( ..... )  
 (гарын үсэг) (нэр)  
 ..... оны..... сарын.....өдөр